



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/1452

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 18 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн үед ариутгал, халдваргүйтгэлийн дэглэм мөрдүүлэхэд шаардлагатай 50,000 (тавин мянган) ширхэг амны хаалтыг хандиваар ирсэн нөөцөөс, 35,000 (гучин таван мянган) ширхэг нэг удаагийн бээлийг худалдан авахад зориулж 3,500,000 (гурван сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсугай.

2. Хөрөнгө оруулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231012152

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 23 өдрийн 4152
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Гоо ширхэг	Мөнгөн дүн
1	Нэг удаагийн бээлий	ш	35000	100
Нийт үнэ				3.500.000